


Батлав. БОАЖЯ – Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

..... / А. Энхбат /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “Тахилт хайрхан транс” ХХК-ийн гүйцэтгэх захирал

..... / Лай Жэнь Бао /



**“ТАВАНТОЛГОЙ – МАНЛАЙ – ХАНГИ ЧИГЛЭЛИЙН ХҮНД ДААЦЫН АВТО ЗАМ
БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР - 6284655/

Хянасан:

БОАЖЯ-Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

..... / П. Шинэцэцэг /

Боловсруулсан:

“Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны ахлах мэргэжилтэн

..... / Б. Лхагважаргал /

2023 он



TAKHILT KHAIKHAAN TRANS
LLC

ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,

Их Монгол Улсын гудамж,

Моннис Бьюлдинг, 6-р давхар

Утас: + (976) 88109158

Email: admin@tkl.mn

2023.06.26 № 23/203
танай _____ ны № _____ д

БОАЖА – ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Төлөвлөгөө батлуулах тухай

Манай компани Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газартай байгуулсан концессийн гэрээний дагуу “Тавантолгой – Манлай – Ханги” чиглэлийн хатуу хучилттай 470.90 км авто зам барих төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны 2-р сарын 08-ны өдрийн 2019/J207 дугаар бүхий төслийн Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээ, Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн зөвлөмж чиглэл, Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 05-р сарын 15-ны өдрийн ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмж, чиглэлүүд болон БОАЖА-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот бүхий журмын дагуу боловсруулсан 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүргүүлж байна.


Иймд 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөг хянан батлаж, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

赖真宝

ЛАЙ ЖЭНЬБАО



Батлав. БОАЖЯ – Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

..... / А. Энхбат /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “Тахилт хайрхан транс” ХХК-ийн гүйцэтгэх захирал

..... / Лай Жэнь Бао /

**“ТАВАНТОЛГОЙ – МАНЛАЙ – ХАНГИ ЧИГЛЭЛИЙН ХҮНД ДААЦЫН АВТО ЗАМ
БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР - 6284655/

Хянасан:

БОАЖЯ-Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах
мэргэжилтэн

..... / П. Шинэцэцэг /

Боловсруулсан:

“Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны ахлах мэргэжилтэн

..... / Б. Лхагважаргал /

2023 он

Байгаль орчны менежмент төлөвлөгөөний агуулга

1. Төслийн товч танилцуулга	4
1.1. Төслийн нэр	4
1.2. Төслийн зорилго.....	4
1.3. Төсөл хэрэгжүүлэгч.....	4
1.4. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил.....	4
1.5. Эрх бүхий зөвшөөрөл.....	5
2.Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	6
2.1 Аймгуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл.....	6
2.2 Сумдуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл.....	8
3.Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлийн товч тодорхойлолт	10
3.1 Агаар:	10
3.2 Усан орчин:.....	10
3.3 Хөрсөн бүрхэвч:	10
3.4 Ургамлан нөмрөг:	10
3.5 Амьтны аймаг:	10
3.6 Нийгэм эдийн засгийн нөлөөлөл:.....	11
4.Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	11
4.1. Байгаль орчны хамгаалах үндсэн чиглэл:.....	11
4.2. 2023 онд зам барилгын төслийн ажлын төлөвлөлт:	12
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө:	18
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:	31
6.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын карьеруудын техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	37
6.2. Зам ангийн түр кемп байсан газрын техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	64
Дээр танилцуулсан туслан гүйцэтгэгч, дэд гэрээлэгч компаниуд нь зам барилгын ажлын гэрээний үүргээ дуусаад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	65
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө:	65
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:	66
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө:	68
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр:	71
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө:.....	73
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө:	76

13. 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал: 77

1. Төслийн товч танилцуулга

1.1. Төслийн нэр

“Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хүнд даацын авто зам байгуулах”

1.2. Төслийн зорилго

Концессын тухай хуулийн 6.2.12, Улсын Их Хурлын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 20 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 238 дугаар тогтоолуудыг үндэслэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний уурхайгаас, Ханги боомт хүртэлх замыг хүнд даацын хатуу хучилттай автозамыг барьж байгуулах болно.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч

Төслийн захиалагч: “Засгийн газрын тохируулагч агентлаг ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР”

Төсөл хэрэгжүүлэгч: “Тахилт хайрхан транс” ХХК

Төслийн туслан гүйцэтгэгч: “Эй энд би инженеринг” ХХК

1.4. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил

Төлөвлөж буй авто замын трасс нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумд болон Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын зарим нутаг дэвсгэрийг хамарсан 470.90 километр урт авто зам байна. Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт нийт 8 багийн нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрнө.



Зураг 1. Замын төслийн зураг

Төслийн замын трассыг ЗТХЯамны сайдын баталсан замын чиглэлтэй давхцуулж төлөвлөсөн. Мөн дайран өнгөрч буй сум орон нутгийн саналыг харгалзан үзэж хамтран ажилласан. Авто замын төгсгөл нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги боомтын ачаа тээврийн орцтой нийлж дуусч байна. Замын трассыг “Эрдэнэс таван толгой нүүрсний уурхай” бусад уурхай, сумуудын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн болно.

Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сум, мөн Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын засаг дарга болон холбогдох байгууллагуудаас газар олголтын болон түгээмэл тархацтай материал авахтай холбоотой зөвшөөрөл, захирамжуудыг гаргуулсан. Төлөвлөгдөж буй авто замын тухайн газар орны онцлог, барилгын ажлын цар хүрээ зэргийг харгалзан захиалагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр төслийн замыг 12 хэсэгт хувааж авто замын зураг төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар нь “Тахилт хайрхан транс” ХХК-тай 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан ба энэхүү төслийн хүрээнд “Тахилт хайрхан транс” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хүнд даацын тээврийн хэрэгслийн авто зам”-ын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын тайланг “Мон газар экологи” ХХК нь гүйцэтгэсэн.

1.5. Эрх бүхий зөвшөөрөл

- Концессын тухай хуулийн 6.2.12, Улсын Их Хурлын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 20 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 238 дугаар тогтоолууд,
- Зам, тээвэр хөгжлийн яамны Сайдын 2019 оны 326-р тушаал
- БОАЖЯ-ны 2019.12.26-ний өдрийн 13/ тоот Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт
- 2019.10.17-ны өдрийн А/223, 2019.12.11-ны өдрийн А/288 тоот Өмнөговь аймгийн Цогтцэций сумын засаг даргын “Замын трасс тогтоох тухай” захирамж
- 2020.07.23-ны өдрийн Өмнөговь аймгийн Манлай сумын засаг даргын “Авто замын трассын зураг хийх газрыг батлах тухай” А/95 тоот захирамж
- 2019.10.09-ны өдрийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын А/124

тоот “Тавантолгой-Манлай-Ханги авто замын чиглэлийг тогтоож, газар ашиглуулах тухай захирамж

- 2020.04.28-ны өдрийн Дорноговь аймгийн засаг даргын “Зөвшөөрөл олгох тухай” А/364 дугаар захирамж /карьер ашиглах зөвшөөрөл/
- 2020.04.28-ны өдрийн Өмнөговь аймгийн засаг даргын “Авто замын бүтээн байгуулалтын ажилд ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгох тухай” А/445 тоот захирамж /карьер ашиглах зөвшөөрөл/
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Эргэл багийн 01, Агаруут багийн 01/05, Аман ус багийн 04 тоот иргэдийн нийтийн хурлын тогтоол, тэмдэглэл
- Өмнөговь аймгийн Манлай сумын Жаргалант багийн 01/01, Өгөөмөр багийн 08/01 тоот иргэдийн нийтийн хурлын тогтоол, тэмдэглэл, Цогтцэций сумын Цагаан Овоо багийн 06 тоот, иргэдийн нийтийн хурлын тогтоол тэмдэглэл зэрэг болно.

2.Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

2.1 Аймгуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Өмнөговь аймаг : Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 59 багтай. Аймгийн төв нь Даланзадгад хот. Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай.

Газарын гадарга, газарзүйн байрлал: Өмнөговь аймгийн нийт нутаг дэвсгэр нь Алтайн өвөр говь, Галба-Өөш-Долоодын говь, Онги, Таац, Умардын говийн гүвээт-Халхын голын гэсэн ай савуудад хамрагддаг байна. Аймгийн нутаг дэвсгэр ерөнхийдөө говь, цөлөрхөг хээр зонхилсон байх ба Говь Гурван Сайхан уулын Байгалийн нөөц газар, Загийн ус Байгалийн цогцолборт газар, Говийн бага (А, Б) Дархан цаазтай газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газрууд байна. Аймгийн нутаг төв хэсэгтээ хамгийн өндөрлөг буюу далайн түвшнээс дээш 2800м, бусад хэсэгтээ нам дор газар буюу д.т.д 1090м орчим өндөрт өргөгдсөн байна. Монгол орон өргөргийн дагуу сунаж тогтсон, хойноосоо урагш чиглэлд байгалийн эрс тэс онцлог бүхий уулын тайга, өндөр уул, ойт хээр, нугат хээр, хээр, хуурай хээр, цөлжүү хээр, заримдаг цөл, умардын цөл, жинхэнэ цөл, говь цөл гэсэн бүс бүслүүрүүд оршдог. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр хуурай хээр, цөлийн хээр, умардын цөл, заримдаг цөл, цөл, жинхэнэ цөл гэсэн бүс бүслүүрт ямар нэгэн хэмжээгээр хамрагдаж байна

Өмнөговь аймгийн нутгийн баруун тал, төв хэсэг рүү Говийн Алтайн нурууны салбар уулс түрж ордгоос аймгийн баруун болон төв хэсэг нь нилээд уулархаг байдалтай юм. Аймгийн нутгийн зүүн хойт хэсэгт орших Шанхай Өгөөмөрийн жижиг уул, нуруудыг оруулаад, нийт уул нуруудын эзлэх талбай аймгийн бүх нутгийн 18%-ийг эзэлнэ. Энэ байдлаас үзэхэд аймгийн нутаг нь ерөнхийдөө талархаг байдалтай байна. Талархаг гадаргуутай нутаг нь дотроо: жижиг уулс, цав толгод, ухаа гүвээ талархаг газар, хогос хонхортоо хужир марзтай тойром, жижиг довцог элс, манхан бүхий нам дор газар гэсэн хоёр хэсэгт хуваагдах бөгөөд жижиг уулс, цав толгод ухаа гүвээ бүхий талархаг газар нь аймгийн нутгийн зүүн хойт хэсэгт, өндөр уулсын бэл дагуух нутгуудыг хамарч аймгийн нийт нутгийн 56%-ийг эзэлнэ. Харин хогос хонхортоо хужир марзтай тойром, жижиг довцог элс, манхан бүхий нам дор газарт аймгийн нутгийн хойт хэсгээр түрж орж ирэх Олон нуруудын хөндийн төгсгөл болох Онгийн голын адаг, Улаан нуурын сав дагуух нутаг болон Борзон Галбын говь, тэрчлэн Нэмэгт уулын ар хоолой, Ингэн сэвстэй, Цайлангийн говийг дайрч улсын хилийн дагуу үргэлжлэх Алтайн өмнөд говийн зүүн үзүүр болох нам дор газар нутгууд орно. Нам дор газрууд нь аймгийн нутгийн 26%-ийг хамарна. Аймгийн газар нутгийн гадаргуугийн энэхүү онцлог шинж нь аймгийн байгаль цаг уурын нөхцөлд зохих ёсны нөлөөг үзүүлдэг. Тухайлбал тус аймгийн баруун өмнөт талын нам дор нутгуудад намрын хүйтрэлт нилээд аажуу орж, хавар эрт дулаардаг бол уулархаг нутаг, түүний дотор Гурвансайханы нуруу дагуух нутгуудад намар эрт хүйтэрч, хавар хожуу дулаардагас хүйтний улирал харьцангуй урт болдог байна. Тус аймгийн нутгийн уул нурууд нь баруунаасаа зүүн тийш чиглэсэн тогтоцтой, урт сунгуу хэлбэртэй юм. Мөн уул нурууд нь хоорондоо элсэн довцог, манхан хужир марзтай хогос, тойром элбэгтэй нарийн хөндий хоолойнуудаар зааглагдана.Түүнчлэн хойноосоо урагш үелэж зэрэгцсэн байрлалтай болно.

Тус аймгийн нутагт нийтдээ 32.2 мян.га талбайг элс эзэлж байна. Үүний 40 орчим хувийг нүүдэг элс эзэлдэг. Сэврэй сумын Хонгорын элсэн уул нь 180-д км урт, зарим газартаа 20 км өргөн юм. Аймгийн газрын гадаргуугийн өндөршилтийн зургаас үзэхэд далайн түвшнээс дээш 1000 метр

хүртэл өргөгдсөн нутаг 5321.7 м.га, 1000-1400 метрт 8633.0 мян.га, 1400-1800 метрт 2074.9 мян.га, 1800-2400 метрт 468.2 мян.га, 2400 метрээс дээш өргөгдсөн нутаг 18.5 мян.га байна. Өөрөөр хэлбэл нийт нутгийн дийлэнх хувийг далайн түвшнээс дээш 1000-1400 метрт өргөгдсөн жижиг уул, толгод, ухаа гүвээ, тэгшивтэр гадаргуутай нутаг эзэлж байна

Уур амьсгал: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь Төв Азийн хуурай, хуурайдуу говь, цөлийн бүсэд багтах бөгөөд далайн түвшинээс дээш 1300-1600м-н дундаж өндөрт оршино. Нутаг дэвсгэрийн хувьд хайрга чулуу элс ихтэй тачир сийрэг бэлчээрийн ургамалтай, уул нуруу, хонхор хөндий, тэгш тал, говь цөл алаглан оршдог. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөрөгийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг хуурай агаартай хөрсөнөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учираас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг ч нар салхины эрчим хүчний их нөөцтэй нутаг юм.

Дорноговь аймаг: Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. Аймгийн төв нь Сайншанд хот. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин суудаг. Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүдийн, улирлын ажиллагаатай Баянбулаг-Мандалын боомтуудтай. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол улсын хөгжил дэвшлийн нэгэн үүд хаалга болж хөгжих ирээдүйтэй.

Боловсрол эрүүд мэнд: Манай аймагт ЭМШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын МСҮТөв, Ерөнхий боловсролын төрийн өмчийн 21, хувийн 1 сургууль, 17 дотуур байр, төрийн өмчийн 32, хувийн 4, төмөр замын 4 цэцэрлэг, эрүүл мэндийн 100 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн нэрэмжит "Саранхөхөө" театр, Иргэдийн хөгжил төв, Усан спорт сургалтын төв, Төв номын сан, Музей сургалт судалгааны төв, Ноён хутагт Данзанравжаагийн музей, Орон нутгийн 2 телевиз, “Өнөөгийн Дорноговь” сонин зэрэг соёл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аж үйлдвэр тээвэр: Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эцэст 230.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 68.5 (42.2%) тэрбумаар өссөн байна. Үүнд уул уурхайн салбарын үйлдвэрлэлт 55.1 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 27.8 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 38.0 хувиар тус тус өсчээ.

Гадаргад нь кайнозойн эриний хурдас их тархсан бөгөөд хайлуур жоншны орд олонтой. Зэс молибден (цагаан суварга), чулуун нүүрс (Алагтогоо), төмөр (Чандмань уул) болон барилгын материалын баялаг бий. Хайлуур, жонш олборлох уурхай байдаг. Дорноговь аймгийн нутгаар төмөр зам нэвтрэн өнгөрөх бөгөөд Сайншанд хот нь манай орны төмөр замын чухал зангилаа юм. Дорноговь аймгийн Замын-Үүд, Хангийн хилийн боомт нь Монголоос Хятад руу гарах хилийн том боомт юм.

2.2 Сумдуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Өмнөговь аймаг Цогтцэций сум: Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Нийслэлээс 540 км, аймгийн төвөөс 100 км зайд, өөрийн аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэн, далайн түвшинээс 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна.

Булаг, шанд, уул, толгод, говь хөндий, хоолой хослосон байгалийн эрдэнэс баялагаар баян, Монгол Улсын баатар эмэгтэй Т.Борын өлгий нутаг, Гэсэр гэлэнгийн домогт хурдан хул мориор домголсон Говь шанхын хурдан удмын адуу, арвин баялаг нөөцтэй “Тавантолгой” нүүрсний орд зэргээр алдартай, нутаг юм.

Тус сум нь чулуун нүүрс, Гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, алт, зэс, хужир зэрэг эрдэс баялгаа хөрсөн дороо агуулсанаас гадна эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж түүнийг даган сум орон нутагт дэд бүтэц хөгжиж, хөгжил цэцэглэлтийн шинэ эрин үетэй зэрэгцэн хөгжих боломж бүрдсэн нутаг юм. “Таван толгой” ХК, “Энержи ресурс”, “Эрдэнэс таван толгой” зэрэг уул уурхайн томоохон компаниуд олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулж байна. Засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай, Сумын хэмжээнд 6 төсөвт байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Өмнөговь аймаг Манлай сум: Одоогоос 270 гаруй жилийн тэртээ байгуулагдсан Түшээт хан аймгийн Сүндэв гүний хошуунаас 9 ноён үе залгамжлан захирч ирсэн хошуу нутагт өнөөгийн Манлай сум 1924 онд анх байгуулагджээ. Улаанбаатар хотоос урагш 470 км, аймгийн төвөөсөө зүүн тийш 230 км зайд өөрийн аймгийн Ханбогд Цогтцэций, Баян-овоо болон Дундговь, Дорноговь аймгуудтай хил залган оршдог. Тус сум нь Засаг захиргааны анхан шатны нэгж болсон дөрвөн багтай. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй.

Сүүлийн 5 жил дараалан адуугаараа аймагтаа тэргүүлж яваа хурдан адууны өлгий нутаг. Нутгийн хурдан удмаас Хүй мандал 1917 оны үед Улхийн булан гэдэг газар болсон 7 хошуу даншиг наадмуудад түрүүлж айрагдаж байсан тухай тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Мөн нутгийн иргэн Ц.Оюунбаатарын санаачилсан “Тэмээн поло” спортыг орон нутагтаа хөгжүүлэхэд онцгой анхааран ажиллаж тодорхой амжилтанд хүрч байгаа Эдийн засгийн хөгжлийн бас нэг гол суваг нь Оюутолгой, Гашуун сухайтын хилийн боомтыг Улаанбаатартай холбосон төв зам, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн төв дөрвөн замын уулзвар дайран өнгөрдөг их замын газар бөгөөд цаашид Дундговь аймгийн Өлзийт сумын Өөш манханы элсэн сувиллаас Морин толгойн цав, Өехий, Сэвхүүл, Могойт, Хоёр өлзийт уул, Ханбогд уул, Баян гол, Амтгай, Аргалант, Сүйхэнт, Өлгий хийд, Ханбогд сумын Галбын гурван хийд хүртэл аяллын маршрут зохион байгуулбал 100-150 км замд Манж Чин улсын үеийн өртөө замын үлдэгдэл, байгалийн сонин тогтоц бүхий газар орон чулуужсан яс, мод, загасны болон ургамлын дүрс бүхий чулуу, аргаль, янгир, хар сүүлт үзэхийн зэрэгцээ хулан, элсэн манхан, тэмээ, заган ой зэргийг нэг дороос үзэх, зураг авах боломжтой аяллын чиглэл гаргаж болох онцлогуудтай сум юм.

Өмнөговь аймаг Ханбогд сум: Хээр таль, говь цөл хосолсон 1515.2 кв.км нутаг дэвсгэртэй. Аймгийн төвөөс 260 км зайтай. Өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэдэг. Өмнөговь аймгийн есөн гайхамшигийн нэг Галбын говь энэ сумын нутагт оршдог. Тус сум засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай. Сумын хэмжээнд 6 төсөвт байгууллага үйл ажиллагаа явуулж түүнд 100 гаруй төрийн албан хаагч ажилладаг. Газрын хөрсөндөө алт зэсийн арвин баялаг нөөцтэй, эрт галавын үеийн аварга гүрвэл, мөлхөгчдийн үлдэгдэл, чулуужсан мод зэрэг ховор олдворуудтай.

Ханбогд сумаас баруун тийш 40 км зайд дэлхийд томд тооцогдох зэс, алтны уурхай болох Оюу толгой үйл ажиллагаа явуулдаг. Монгол улсын эдийн засагт үлэмж хэмжээний үр ашиг авчрах аварга том уурхайн төсөл бөгөөд 2017 оны 12-р сарын 27-нд баяжуулах үйлдвэр нь ашиглалтанд орсон. Ханбогд сумаас баруун урагш 12 км зайд дуу шүлгэнд мөнхөрсөн Галбын говьд Ноён хутагт Данзанравжаагийн байгуулсан алдарт гурван хийдийн туурь, Цогзолын хийдийн туурь Алтангэрэлийн дугуй, Ловончомбын баяжуулдаг Чавгын агуй, Ходоод ба нүдний рашаан, элэг цөсний чулуу зэрэг байгаль түүхийн сонин тогтоц бүхий олон дурсгалт газруудтай. Дэмчогийн хийдийг Өмнөговийн “Ажнай” корпорациас санхүүжүүлэн сэргээн босгосон нь дотоодын аялал хөгжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Дэмчогийн хийдээс баруун хойно 6 км орчимд “Дэлхийн энергийн төв” жуулчны бааз байгуулагдсан. Сумын төвд цэвэр, бохир усанд холбогдсон цөөнгүй зочид буудал, ресторанууд үйл ажиллагаа явуулдаг. Төслийн байгаль орчны төлөв байдал: Төслийн хэрэгжих газрын хөрсөн бүрхэвчид 11 цэгт 30 см-н зүсэлт хийж тодорхойлоход pH-9.1-10.4, давсжилт 0,2-1,77% ялмаг 0,06-1,24 % 0,025-0,05 мм-н голчтой ширхэглэлт 11,4-79,4% эзэлсэн байдалтай хөрстэй.

Төслийн хэрэгжих бүс нутаг замын трассын дагуу говийн хялгана, харлаг үмхий өвс, сайрын хялгана, бор бударгана, намхан гишүүнэ, зүүнгарын хазаар өвс, таана, монгол сонгино, алтан харгана, орог тэсэг, төлөгчдүү боролз, ахар навчит багалуур, улаан бударгана, говийн хэрээн нүд, дэрэвгэр хавьсгана, цөлийн тайр, ямаан ангалзуур, розовын хотир, саваан булган сүүл, бага хургалж аалзны хуш өвс, ямаан шарилж, навчирхаг бадаргана, шүлхий шарилж, хулан хойрог, модлог бударгана, шинэсэрхүү бударгана, шар хотир, сибирь хотир, монгол азар, зайсангийн заг зэрэг ургамлууд элбэг тохиолдоно. Харин ховор ургамлуудаас гэвэл элдэв навчит улиас, грубовы хөөндий, зөөлөн лавай, хос шүдэт синтрихи, газрын үс, говийн харлаг, зүүн гарын гоёо юм.

Агаарын чанарын хувьд төслийн трассын хувьд агаарын чийгшил дунджаар 21% агаар бохирдуулах эх үүсвэр нь тээврийн хэрэгсэлийн утаа болон түүнээс үүсэх тоосжилт дуу чимээ зэрэг юм.

Уг төсөл хэрэгжиж хатуу хучилттай зам тавигдсанаар байгаль орчинд маршрутын бус зам гарахгүй хөрсөн бүрхэвч хамгаалагдах, агаарын бохирдол тоосжилт эрс буурах ургамалжилт хөрсний чанар сайжирч хамгаалагдсанаар амьтны аймаг хамгаалагдах тустай. Өөрөөр хэлбэл хатуу хучилттай зам байгаль орчныг шороон замтай байсан үеэс илүү хамгаалж дээрдүүлнэ.

Нийгэм эдийн засгийн хувьд хатуу хучилттай зам тавигдаж дууссаны дараа улс орон, нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэртэй ба орон нутгийн ачаа эргэлтийг сайжруулах, хүн амыг зах зээлд ойртуулах, тээврийн хэрэгслийн эвдрэл саатлыг бууруулах зэрэг эерэг нөлөөллүүдээс гадна дам нөлөөлөлүүд ч мөн олон байна.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлтийн товч тодорхойлолт

Авто замын төслийн БОНБНУ-нд төслийн нөлөөллийг БОНХ-ийн Сайдын 2014 оны 4 сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлал”-г баримтлан Магадлан жагсаах болон Леопольдын матрицын аргаар тодорхойлсон.

Төслийн орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Шууд нөлөөллийн бүс нь түр замын 581,3га, элс хайрганы карьеруудын 357,3га талбай байна. Нөлөөллийн бүсийг урьдчилан тогтоохдоо нөлөөлөл бүх чигт жигд тархана гэж үзсэн байна. Нөлөөлөлд төсөл хэрэгжих орчны агаарын чанар, гадаргын болон гүний ус, ургамал, хөрсөн бүрхэвч амьтад өртөнө.

Нөлөөллийн бүсийг эдэлбэр газрын гаднах бүсээс 1км радиус дотор байхаар тооцсон байна.

3.1 Агаар:

Төслийг хэрэгжүүлэх явцад зам тавих зурвас тэгшилгээний ажил, гуур далан суваг шуудуу байгуулахад замын ажилд ашиглаж буй техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөн, түүхий эд тээвэрлэх, шороо чулууны карьер ашиглах явцад тоосжилт богино хугацаанд үүснэ. Мөн агаарт машин техникийн ажиллагаанас бага оврын дизель генератор станц ашиглах үед төхөөрөмжийн түлшний шаталтаас агаарт хий богино хугацаанд тухайн орчинд цацагдана.

3.2 Усан орчин:

Хог хаягдал шатах тослох материалын асгаралт болзошгүй осол аюулаас шалтгаалсан усан орчны физик химийн шинж чанарт нөлөөлөл үүсгэх магадлалтай

3.3 Хөрсөн бүрхэвч:

Төсөл хэрэгжих явц болон хатуу хучилттай зам тавихаас өмнө маршрутын бус гарах хүн амын төвлөрлөөс хөрсөн бүрхэвч эвдэгдэх, шимт чанар буурах зэрэг богино хугацааны нөлөөлөл гарах, мөн техникийн шатах тослох материалын гэнэтийн ослоос шалтгаалсан нөлөөлөл гарна. Хатуу хучилттай зам талбай бий болсноор маршрутын бус зам гарахгүй болох, зам зуурын машины гэнэтийн элэгдэл эвдрэл буурах ингэснээр хөрсний бохирдол багасах зэрэг нөлөөллийг үзүүлнэ. Мөн замын түүхий эд болох элс хайрганы карьер ашиглалтаас хөрсний эвдрэл үүснэ.

3.4 Ургамлан нөмрөг:

Хатуу хучилттай зам барьсаны дараа маршрутын бус зам давхар гарахгүй болсноор хөрсний элэгдэл эвдрэл багасч шимт чанар ахиснаар ургамлан бүрхэвч сэргэх нөлөөллийг үзүүлнэ. Төсөл хэрэгжих хатуу хучилттай зам барих явцад богино хугацааны турш төслийн ажиллах хүчний төвлөрсөн кэмп, техникүүдийн орчимд ургамлан бүрхэвч талхлагдана.

3.5 Амьтны аймаг:

Дуу чимээ хүн амын төвлөрлөөс жижиг хөхтөн амьтан төслийн ойр орчмын нүхэнд амьдардаг организмууд даажих нөлөөллийг үзүүлнэ. Төсөл хэрэгжиж хатуу хучилттай зам тавигдсаны дараа хөрс ургамлан бүрхэвч сэргэснээр амьдрах орчны тэтгэх даац нэмэгдвэл амьтны төрөл зүйл тоо толгой өсөх нөлөөлөл үзүүлж болно. Мөн зам тавигдсанаар амьтны амьдрах орчыг хуваах фрагментацид оруулах боловч үүнийг сөрөг эерэг нөлөөлөл гэж ангилах боломжгүй юм.

3.6 Нийгэм эдийн засгийн нөлөөлөл:

Төслийг хэрэгжүүлэх явцад татварын орлого, бүтээгдэхүүн үйлчилгээ, худалдан авалт, ажлын байр шинээр бий болгох зэрэг богино хугацааны эерэг нөлөөллийг үзүүлэх бол урт хугацаанд карго, бараа эргэлт ажлын байрууд бий болох шинэ бизнесийн эхлэлүүдийг нээх ач холбогдолтой.

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

4.1. Байгаль орчны хамгаалах үндсэн чиглэл:

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Тахилт хайрхан транс” ХХК нь “Тавантолгой-Манлай-Ханги боомт хүртэлх авто зам”-ын төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- ✓ Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- ✓ Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- ✓ Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтанд хамрагдах боломжтой болно.
- ✓ Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- ✓ Сум орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Тус төлөвлөгөөний гол зорилго нь БОННУ-ний тайлангийн “Бүлэг 5”-т тодорхойлсон гол сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгахад оршино. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, зөвлөгөөний “Мон газар экологи” ХХК “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 477.0 км хүнд даацын автозам байгуулах” төслийн Байгаль орчны нөлөөллийн

нарийвчилсан үнэлгээний тайлан нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Тахилт хайрхан транс” ХХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

“Тахилт хайрхан транс” ХХК-ийн Авто замын төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд байна. Иймд төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээг огтхон ч орхигдуулж болохгүй төдийгүй байгаль орчныг хамгаалах зардлыг хүрэлцээтэй төлөвлөж байгаль орчинг хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эдгээр нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байж болох хамгийн бага түвшинд аваачих ач холбогдолтой юм.

Мөн нутгийн иргэдийн санал хүсэлтийг сонсох, иргэдтэй хамтарч байгаль хамгаалах талаарх асуудлыг шийдвэрлэх санал, хэлэлцүүлэг зохиох, төслийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал, гомдлыг сонсох, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зэргээр орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах, иргэдийг ажлын байраар хангах, тэднийг дэмжих үйл ажиллагааг байнга хэрэгжүүлж байх нь зүйтэй юм.

4.2. 2023 онд зам барилгын төслийн ажлын төлөвлөлт:

2023 оны зам барилгын ажлын төлөвлөлтөөр нийт 225 хоног, 1000 ажилтантай ажиллахаар төлөвлөсөн.

2023 онд гүйцэтгэх ажлын хэмжээг доор харуулав.

№	Ажлын нэр	Хэмж их нэгж	Нийт ажлын тоо хэмжээ	Үлдэгдэл ажил Retained works for 2023						Усны норм	Усны хэмжээ
				Тоо хэмжээ Lot-1	Тоо хэмжээ Lot-2	Тоо хэмжээ Lot-3	Тоо хэмжээ Lot-4	Тоо хэмжээ Lot-5	Тоо хэмжээ Lot-6		
No. 2	ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ										
2.2	Ухмалын ул хөрсийг тэгшлэж нягтруулах	1м3	38,553.92	26,756.79	9,150.57	172.87	640.06	819.90	1,013.73	0.06	2,313.24
2.3	Далангийн ул хөрсийг тэгшлэж нягтруулах	1м3	369,803.87	225,276.10	105,495.04	32,626.49	3,678.40	2,437.38	290.46	0.06	22,188.23
No. 3	ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ										
3.5	Зөөврөөр далан байгуулах	1м3	1,911,955.53	410,409.86	1,000,029.93	191,498.89	149,341.27	39,347.20	121,328.38	0.08	152,956.44
No. 4	СУУРИЙН АЖИЛ										
4.1	Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь	1м3	786,915.96	108,551.20	195,347.86	141,724.98	137,950.47	138,534.04	64,807.41	0.05	39,345.80

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

	байгуулах /6-8%/ h=0.2м 6-8 %											
4.2	Хөрсийг цементээр бэхжүүлж суурь байгуулах /4-6%/ h=0.2м / 4-6%	1м3	774,096.61	113,059.10	203,437.85	147,714.04	124,769.95	129,882.60	55,233.07	0.05	38,704.83	
4.3	Суурийн доод үе байгуулах	1м3	1,206,412.06	191,957.48	405,109.87	257,954.76	137,778.93	131,990.74	81,620.28	0.10	120,641.21	
No. 5	ХУЧИЛТЫН АЖИЛ											
5.1	Давхар гадаргуун боловсруулалт хийх,	1м3	77,975.03	10,411.50	18,725.78	13,543.29	14,065.36	14,300.00	6,929.11	0.01	779.75	
5.2	Хайрган хөвөө байгуулах	1м3	935,584.84	141,568.23	253,349.14	185,776.23	142,333.57	140,118.23	72,439.44	0.09	84,202.64	
No. 6	УС ЗАЙЛУУЛАХ ЭНГИЙН БАЙГУУЛАМЖ,ЯВ ГАН ЗАМ											
6.8	Шуудуунд бетон бэхэлгээ хийх h=0.1м. В15	1м2	254,035.86	33,389.20	47,454.80	34,907.44	78,981.84	40,922.30	18,380.28	0.20	50,807.17	
6.10	Ус чиглүүлэх даланд чулуун бэхэлгээ хийх h=0.2м	1м3	544.86	-	-	-	-	-	544.86	0.02	10.90	
6.11	Зөвөрөөр ус чиглүүлэх далан барих	1м3	1,548.82	-	-	-	-	-	1,548.82	0.08	123.91	
No. 7	ЗАМЫН ТОНОГЛОЛ											
7.8	Тойрог уулзварт тулц бетон цутгах В30	1м3	82.86	-	-	30.08	-	52.78	-	0.20	16.57	
7.10	Тусгаарлах аралд дүүргэлт хийх	1м3	344.73	-	-	123.10	-	221.63	-	0.08	27.58	
7.11	Голын аралд дүүргэлт хийх	1м3	2,773.18	-	-	944.40	-	1,828.78	-	0.08	221.85	
No. 10	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА CONCRETE PIPE CULVERT											

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

10.2	Хоолойн ул суурь нягтруулах	1м2	31,869.70	9,968.65	15,807.33	5,710.70	239.34	143.68	0.00	0.06	1,912.18
10.3	Зохистой ширхэглэл бүхий элс хайрган хольцоор суурь байгуулах	1м3	1,945.06	489.89	949.90	490.80	9.16	5.32	-	0.03	58.35
10.4	Амсрын шал бетон цутгах В30	1м3	2,503.97	446.64	858.38	401.46	611.15	170.14	16.20	0.20	500.79
10.5	Хоолойн тулц бетон цутгах В15	1м3	702.56	74.40	180.00	131.47	163.32	105.37	48.00	0.45	316.15
10.10	Буцаан дүүргэлт хийх	1м3	88,943.20	17,190.72	32,282.30	18,976.04	8,821.02	5,340.35	6,332.77	0.08	7,115.46
No. 11	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА D=1.0M										
11.1	Бетон суурь байгуулах В15	1м3	637.77	69.99	319.71	239.21	(0.00)	-	8.86	0.20	127.55
11.4	Хоолойн их биеийн хэсэглэлд хүчитгэл цутгах В30	1м3	1,203.81	147.23	496.76	479.93	56.07	-	23.82	0.20	240.76
11.5	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В30	1м3	368.13	34.06	117.90	135.69	75.24	-	5.24	0.20	73.63
No. 12	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА 1.5X1.5M										
12.1	Бетон суурь байгуулах	1м3	361.55	169.95	125.68	59.87	6.05	-	(0.00)	0.20	72.31
12.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30	1м3	2,278.61	1,017.76	804.39	323.03	100.69	32.74	-	0.20	455.72
12.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В30	1м3	1,412.24	429.04	544.64	178.00	160.32	73.84	26.40	0.20	282.45
No. 13	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА 2.0X1.5M										
13.1	Бетон суурь байгуулах В15	1м3	35.65	35.65	-	-	(0.01)	-	-	0.20	7.13
13.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30	1м3	192.91	192.91	-	-	-	-	-	0.20	38.58

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

13.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цугтах В30	1м3	119.60	70.00	13.20	-	26.40	10.00	-	0.20	23.92
No. 14	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА /2.0X1.5M/X2										
14.1	Бетон суурь байгуулах В15	1м3	45.22	32.65	11.38	-	0.00	1.19	-	0.20	9.04
14.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цугтах В30	1м3	330.64	254.88	67.26	-	-	8.50	-	0.20	66.13
14.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цугтах В30	1м3	100.00	58.88	27.92	-	13.20	-	-	0.20	20.00
No. 15	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА /2.0X1.5M/X10										
15.2	Хөвөө, далангийн хажуу налууг В15 бетоноор хүчитгэх	1м2	3,907.66	-	-	1,111.01	2,305.47	491.18	-	0.20	781.53
15.4	Бетон суурь байгуулах	1м3	44.25	-	-	44.25	(0.00)	-	-	0.20	8.85
15.5	Хоолойн хэсэглэл суурин дээр цугтах В30	1м3	684.06	-	-	300.60	383.46	-	-	0.20	136.81
15.6	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цугтах В30	1м3	59.16	-	-	20.64	23.44	15.08	-	0.20	11.83
No. 16	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА 2.0X2.0M										
16.1	Бетон суурь байгуулах В15	1м3	168.33	7.42	130.13	30.78	0.00	-	-	0.20	33.67
16.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цугтах В30	1м3	1,195.64	49.70	935.78	210.16	-	-	-	0.20	239.13
16.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цугтах В30	1м3	516.12	19.24	383.12	95.36	18.40	-	-	0.20	103.22
No. 16	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА /2.0X2.0M/X2										

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

16.1 a	Бетон суурь байгуулах	1м3	48.32	11.70	36.62	-	(0.00)	-	-	0.2 0	9.66
16.2 b	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30	1м3	429.24	88.20	341.04	-	-	-	-	0.2 0	85.85
16.3 c	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В30	1м3	118.20	19.96	79.84	-	18.40	-	-	0.2 0	23.64
No. 17	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА										
17.1	Бетон суурь байгуулах В15	1м3	25.70	17.08	-	-	8.62	-	-	0.2 0	5.14
17.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30	1м3	181.23	120.27	-	-	60.96	0.00	-	0.2 0	36.25
17.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В30	1м3	76.60	38.80	18.40	-	19.40	-	-	0.2 0	15.32
No. 17	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА /2.5X2.0M/X2										
17.1 a	Бетон суурь байгуулах В15	1м3	47.50	47.50	-	-	(0.00)	-	-	0.2 0	9.50
17.2 b	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30	1м3	509.53	398.90	110.62	-	0.00	-	-	0.2 0	101.91
17.3 c	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В30	1м3	154.72	60.84	38.68	-	55.20	-	-	0.2 0	30.94
No. 18	ТӨМӨРБЕТОН ХООЛОЙН БАРИЛГА /2.5X2.0M/X3										
18.1	Бетон суурь байгуулах В15	1м3	18.54	-	-	18.54	0.00	-	-	0.2 0	3.71
18.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В30	1м3	425.14	-	102.33	157.14	165.67	-	-	0.2 0	85.03
18.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В30	1м3	82.00	-	21.20	21.20	39.60	-	-	0.2 0	16.40

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

No. 19	МАЛ, АМЬТНЫ НҮХЭН ГАРЦ 3.0X5.0M										
19.1	Бетон суурь байгуулах В15	1м3	116.79	51.62	-	65.17	-	-	-	0.20	23.36
19.2	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В40	1м3	1,017.08	420.48	118.68	477.92	-	-	-	0.20	203.42
19.3	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В40	1м3	364.08	107.08	51.40	205.60	-	-	-	0.20	72.82
No. 19	МАЛ, АМЬТНЫ НҮХЭН ГАРЦ /3.0X5.0M/X2										
19.1 a	Бетон суурь байгуулах В15	1м3	119.72	-	117.36	-	0.00	2.36	-	0.20	23.94
19.2 b	Хоолойн хэсэглэл суурин дээр цутгах В40	1м3	1,135.71	-	1,111.52	-	-	24.19	-	0.20	227.14
19.3 c	Хоолойн толгой, далбааны хэсэглэл цутгах В40	1м3	464.46	-	366.22	-	98.24	-	-	0.20	92.89

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө:

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн бичиг баримт	
Агаар орчин хамгаалал										
1	Тоосжилт үүсэх	Зам тавих зурвасыг тэгшилгээний ажил хийх, гүүр, далан, суваг шуудуу байгуулахад элэгдэл, эвдрэлд орсон газар	Шороон далангийн шороон материалыг аль болох түргэн хугацаанд тэгшилж хайрга, буталсан чулуун үеэр хучилт хийх, услаж нягтаршуулна.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	М³	Усны төлбөр тооцох аргачлалын хүрээнд	Гүйцэх ажлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Агаарын тухай хууль (2021-05-17) 9-р зүйл Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 2016
2		Замын ажилд ашиглаж байгаа машин техникийн хөдөлгөөнөөс	Тоосжилтын төвшинг хяналтын цэгүүдэд хэмжилт хийнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 13 заалт)	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	М³	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Гүйцэх ажлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Агаарын тухай хууль (2021-05-17) 9-р зүйл Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 2016
3		Түүхий эд тээвэрлэх	Түүхий эд, хөрс шороог ачиж буулгах, тээвэрлэх ажлыг аль болох агаар тогтуун, салхи багатай үед гүйцэтгэж, тоосны тархалтыг багасгах, зам засварын ажлыг тогтмол гүйцэтгэнэ.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	Га	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Эвдрэлд орсон замын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Агаарын тухай хууль (2021-05-17) 9-р зүйл Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

										MNS 4585 2016
4		Шороо, чулууны карьер ашиглах	Үйлдвэрийн услагааны системийг ашиглах, тоос бөөнцөглөх бүсийг тодорхойлно.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	М³	Усны төлбөр тооцох аргачлалын хүрээнд	Дүүргэгч материал бутлах ажлын тоо хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Агаарын тухай хууль (2021-05-17) 9-р зүйл Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 2016
5	Хорт хий агаарт дэгдэх	Төсөлд хэрэглэж байгаа машин техникийн ажиллагаанаас	Агаарын хортой хийн хэмжээ, холимгийн төстийг хяналтын цэгүүд дээр гүйцэтгэнэ.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	Сар бүр 1	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Лот-6*7 сар=Нийт 42 удаа	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Агаарын тухай хууль (2021-05-17) 9-р зүйл Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 2016
6		Бага оврын дизель станц төслийн үйл ажиллагаанд ашиглах	Агаарын хорт бодисын хэмжилтийг хяналтын цэгүүдэд хийнэ.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	Удаа	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Лот-6*7 сар=Нийт 42 удаа	Мониторингийн ажлын зардлаар	2023 оны 2-4 улиралд	Агаарын тухай хууль (2021-05-17) 9-р зүйл Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 2016
7	Дуу чимээний нөлөөлөл	Зам тавих ажилд ашиглах машин техник, бутлан ангилах үйлдвэр болон	Дуу чимээ, чичиргээ доргилтын хэмжилтийг хяналтын цэгүүд дээр гүйцэтгэнэ.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	Удаа	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Лот-6*7 сар=Нийт 42 удаа	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

		асфальт бетоны үйлдвэр								MNS 4585 2016
Усны чанар болон нөөцийн хамгаалал										
1		Эрүүл ахуйн бүс тогтоолгүй худаг, уст цэгийг ашиглах	Худаг, уст цэгүүдэд эрүүл ахуйн бүс тогтоох захирамж гаргуулан, 50-100 м-т эрүүл ахуйн бүсийг тогтоож, тэмдэгжүүлнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 22 заалт)	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	ш	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Зөвшөөрөл авсан бүх уст худгийн тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 22.3-р зүйл
2	Усны хими - физик шинж чанарт өөрчлөлт орох	Аюултай хорт бодис алдагдах, машин техникийн шатахуун асгарах, усан орчинд нэвчих	Асгаралтыг цуглуулан, нэвчсэн бүх хэсгийг бохирдсон хөрс саармагжуулах талбайд хураан, зориулалтын бодисоор саармагжуулна.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	М³	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Асгаралт тохиолдсон тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Ундны усны стандарт MNS 0900 2018
3		Бохир усыг зөвшөөрөлгүй цэгт хаях	Бохир ус хаях цэгийг тогтоосон захирамжтай, тухайн цэгийг хашаажуулж, тэмдэгжүүлсэн байна. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 23, 24 заалт)	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	ш	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Бохир ус хаях цэг тогтоолгосон тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 24-р зүйл Хаягдал усны стандарт MNS 4943 2015
4		Унд ахуй болон үйлдвэрлэлийн усны бохирдол үүсэх	Унд ахуй болон үйлдвэрлэлийн уснаас дээж авч шинжлүүлнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	Удаа	Нэгж шинжилгээний өртгөөр тооцоологдоно.	28 уст худгаас шинижлнэ.	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгав.	2023 оны 2-4 улиралд	Ундны усны стандарт MNS 0900 2018

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

			өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 31 заалт)							
5		Зөвшөөрөлгүй худаг, цооног гаргах	Худаг, уст цэгийг холбогдох зөвшөөрлийг авч гаргуулах, худгийн паспортын бичиглэлийг бүрэн хийх, дотоодын бүртгэлд оруулна. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 27 заалт)	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	ш	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Зөвшөөрөлтэй худгийн тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 27-р зүйл
6	Усны нөөц буурах, багасах	Усны нөөцийг зориулалтын бусаар ашиглах	Ус ашиглах дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар гаргуулах гаргуулах, усны нөөц ашиглалтыг зориулалтаар нь бүртгэлжүүлнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 29 заалт)	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	Удаа	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	1	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 1-2 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 28-р зүйл
7		Тоолууржуулалтгүй худаг, уст цэгийг ашиглах	Ашиглаж буй худаг, уст цэгийн шугам хоолой бүрт батлагаажсан сертификат бүхий лацтай тоолуурыг ашиглалт эхлэхээс өмнө сумын байгаль хамгаалагчийн хяналтан доор	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	ш	Усны төлбөр тооцох аргачлалын хүрээнд	Зөвшөөрөлтэй худгийн тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 29-р зүйл

			суурилуулах, акт үйлдүүлнэ. Хэрэв тоолуургүй ашигласан тохиолдолд нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оногдох усны нормын тооцооллын дагуу гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр тооцон, холбогдох төлбөрийг барагдуулна. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 25,26 заалт)							
8	Зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашиглах	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар гаргуулах, ус ашиглалтын бүртгэлийг улирал бүр гүйцэтгэх, холбогдох төлбөрийг барагдуулна.	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	ш	Усны төлбөр тооцох аргачлалын хүрээнд	Зөвшөөрөлтэй худгийн тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 28-р зүйл	
10	Ашиглалтаас хамаарч усны төвшин буурах, шавхагдах	Усны төвшин хэмжилтийг улирал тутамд гүйцэтгэнэ.	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	Удаа	84	Зөвшөөрөлтэй худгийн тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 28-р зүйл	
11	Ашиглаад дууссан цооногийг битүүмжлэлгүй задгай орхих	Ашиглаад дууссан цооногийг зохих журмын хүрээнд битүүмжлэн, сум орон нутагт хүлээлгэн өгөх, акт үйлдүүлнэ.	Зам барилгын ажлын төслийн усны хангамжийн бүх нөөцөд	ш	Дотоод зардлаар гүйцэтгэгдэнэ	Ашиглалтаас гарсан худгийн тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Усны тухай хууль (2012-05-17) 22.17-р зүйл	

			(Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 28 заалт)							
Хөрсөн бүрхэвчийн хамгаалал										
1	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Төслийн бүтээн байгуулалтын явцад олон салаа зам гарах	Олон салаа замыг хааж нөхөн сэргээж, нэгдсэн маршрутыг тогтооно. Одоо үүссэн байгаа дараах 23 байршил бүхий олон салаа зам үүссэн газруудыг хааж, автогрейдерээр техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэнэ. Тэдгээр байршил нь: Байршил 1. N 430 35' 48'' / E 1070 46' 5'' Байршил 2. N 430 35' 51'' / E 1070 45' 57'' Байршил 3. N 430 35' 51'' / E 1070 45' 56'' Байршил 4. N 430 35' 54'' / E 1070 45' 50'' Байршил 5. N 430 35' 57'' / E 1070 45' 40'' Байршил 6. N 430 36' 2'' / E 1070 45' 27'' Байршил 7. N 430 35' 51'' / E 1070 45' 56'' Байршил 8. N 430 36' 13'' / E 1070 44' 52'' Байршил 9. N 430 36' 19'' / E 1070 44' 20'' Байршил 10. N 430 36' 22'' / E 1070 44' 3''	Ашиглаж буй түр замуудын хэмжээнд	Удаа	Батлагдсан гэрээний хүрээнд	1	Зардал шаардагдахгүй	2023 оны 2-3 улиралд	Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 6.1.6-р зүйл заалт

			Байршил 11. N 430 36' 24'' / E 1070 43' 52'' Байршил 12. N 430 36' 27'' / E 1070 43' 32'' Байршил 13. N 430 36' 29'' / E 1070 41' 10'' Байршил 14. N 430 37' 9'' / E 1070 39' 41'' Байршил 15. N 430 37' 15'' / E 1070 39' 35'' Байршил 16. N 430 37' 44'' / E 1070 39' 4'' Байршил 17. N 430 37' 53'' / E 1070 38' 56'' Байршил 18. N 430 38' 33'' / E 1070 38' 8'' Байршил 19. N 430 36' 6'' / E 1070 37' 17'' Байршил 20. N 430 39' 19'' / E 1070 37' 7'' Байршил 21. N 430 39' 59'' / E 1070 36' 43'' Байршил 22. N 430 44' 16'' / E 1070 31' 57'' Байршил 23. N 430 36' 53'' / E 1070 40' 58'' Дээрх байршлууд нөхөн сэргээгдсэнээс хойш 2-3 жилийн дотор байгалийн унаган ургамал ургах боломжтой.							
2	Түүхий эд материал тээвэртэй холбоотой хөрсний эвдрэл үүсэх	Түр замын засвар, арчилгааг тогтмол гүйцэтгэнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар	Ашиглаж буй түр замуудын хэмжээнд	Өдөр тутам	Батлагдсан гэрээний хүрээнд	Гүйцэхгэх ажлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 7.2.3-р зүйл заалт	

Байгаль орчны менежмент төлөвлөгөө – 2023

			бүхий албан бичгийн 11 заалт)							
3		Карьерийн ашиглалтын явцад хөрсний эвдрэл үүсэх	Карьер ашиглаж дууссан тохиолдолд стандартын дагуу нөхөн сэргээлтийг гүйцэтгэж, хүлээлгэн өгч, акт үйлдэнэ.	Зөвшөөрөлтэй бүх карьерийн хэмжээнд	М³	Тооцоолсон төсөвт өртгөөр	Гүйцэхгэх ажлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд	Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 6.1.4-р зүйл заалт
4	Хөрсний бохирдол үүсэх	Төслийн бүтээн байгуулалтын явцад хөрсний хүнд эльментийн бохирдол үүсэх	Хөрсний хяналтын цэгээс дээж авч, шинжлүүлнэ.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	Удаа	2	48	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгав.	2023 оны 2-4 улиралд	Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 7.2.5-р зүйл заалт Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 2019
5		Шатах, тослох материал хөрсөнд асгарах, Гадаргын идэвхит нийллэг бүтээгдэхүүнээр хөрс бохирдох /бензин, дизель түлш/	Асгаралтын сургалт явуулах, журам танилцуулах ажлыг нийт ажилчдад зохион байгуулна.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	Удаа	6	6	Зардал шаардагдахгүй	2023 оны 2-4 улиралд	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 2019
6		Аюултай хог хаягдлаар хөрс бохирдох	Аюултай хог хаягдлыг ангилан түр хадгалах цэгт түр хурааж, эрх бүхий байгууллагад	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	ш/тон/кг	Тооцоолсон төсөвт өртгөөр	Аюултай хог хаягдлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-3 улиралд	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах

			шилжүүлэн өгч, бүртгэлийг хийнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 19 заалт)							бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 2019
7	Ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох	Ахуйн хог хаягдлыг ангилан түр хадгалах цэгт хурааж, эрх бүхий зөвшөөрөл авч тээвэрлэнэ. Бүртгэлийг хийнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 20 заалт)	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	ш/тон/кг	Хог хаягдлын гэрээнд заасан нэгж төлбөр	Хог хаягдлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд		Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 7.2.1-р зүйл заалт
8	Хоол, үнсний хог хаягдлаар хөрс бохирдох	Хоол болон үнсний хаягдлыг тогтмол ландфил аргаар бүлшилна.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	тон/кг	Тооцоолсон төсөвт өртгөөр	Хог хаягдлын хэмжээгээр	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд		
9	Ахуйн бохир усаар хөрс бохирдох	Бохир ус хаях цэгийг тогтоолгоно. Тухайн цэгтээ бохир усыг хаяна.	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	ш	Хамааралгүй	Төв кемпийн тоогоор	Төсөв шаардагдахгүй	2023 оны 2-3 улиралд		Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 7.2.2-р зүйл заалт
10	Шаардлага хангахгүй нийтийн бие засах газраас үүсэх бохирдол	Нийтийн бие засах газрыг стандартын дагуу байгуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг улирал тутамд гүйцэтгэнэ. (Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны	Зам барилгын ажлын төслийн хэмжээнд	ш	Тооцоолсон төсөвт өртгөөр	Нийтийн бие засах газрын тоогоор	Үйл ажиллагааны дотоод зардлаар	2023 оны 2-4 улиралд		Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн ерөнхий шаардлага MNS 5924 2008

			01-р сарын 30-ний өдрийн 41 дугаар бүхий албан бичгийн 21 заалт) (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 08-р сарын 10-ны өдрийн албан зөвлөмжийн 12 дугаар заалт)						
